



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УБС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



Хөрөнгө оруулалтын зарим ажлын хэрэгжилт дутуу, 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүнд

УВС-2017/1-ГА

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3-4
Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд	Товчилсон үгийн тайлал	5
Аудитын менежер Ж.Энхжаргал	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6-7
Аудитор Я.Тунгалаг	Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.	8
2016 оны 4 дүгээр сар	А.1. Хэтийн төлөвлөгөөг үндэслэн 2016 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	8-9
	А.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар үр нөлөөгүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	9-11
	А.3. Газрын зөвшөөрөл, техникийн нөхцлийг олгосон төсөл арга хэмжээг 2016 онд төлөвлөсөн байна.	
	А.4. Автозамын сангийн эх үүсвэрээр хийгдэх 8 төсөл арга хэмжээг зураг төсөвгүйгээр төлөвлөж, 1 ажлын зурагт өөрчлөлт орсон байна.	11
	А.5. Төсвийн тухай хуулиар зарим төсөл арга хэмжээг хасаж баталсан байна.	12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 7045-4721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	А.6. БСШУЯ-наас хувиарласан хөрөнгөөс 16.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирээгүй байна.	12
	А.7. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулан санхүүжүүлжээ.	13
	Дүгнэлт Зөвлөмж	13
	Бүлэг 2. Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулжээ.	14
	Б.1. Үнэлгээний хороог журмын дагуу хийж ХАА-ны аргыг зөв сонгосон ч, 2 төсөл арга хэмжээг мэдээллээгүй байна.	14
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум Здугаар баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Б.2. Засгийн газрын тогтоол зөрчиж 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	14-15
	Б.3. Хуульд заасан хугацаанд ХАА-г зохион байгуулж, тайлагнасан байна.	16
	Б.4. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 42.6 сая төгрөгийн хэмнэлтийг зарцуулаагүй байна.	16
	Б.5. Худалдан авах ажиллагааны эрх оройтон шилжиж ирснээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	16
	Б.6. ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчлөөгүй байна.	16
	Дүгнэлт Зөвлөмж	16-17
	Бүлэг3. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна	18
	В.1. Гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгч нар төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	19
	В.2. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	19
	В.3. Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон байна.	19
	В.4. Гурван төсөл арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн байна.	20

	В.5.Замын сангаар эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд явцын хяналт хийгдээгүй байна.	21
	В.6. Улсын комиссын акт гараагүй байхад 1 ажлын санхүүжилтийг бүрэн олгожээ.	21
	В.7. Зарим төсөл арга хэмжээний чанар хангалтгүй байна.	22-23
	Дүгнэлт	24
	Зөвлөмж	24
	Холбогдох байгууллагын санал	25-27
	Аудитын газраас өгөх тайлбар	28

Товчилсон үгийн тайлал:

ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ИХШХЕГ-ын	Иргэний харьяатын шилжих хөдөлгөөний ерөнхий газар
ГХБХБГазар	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ААН	Аж ахуйн нэгж
ТАХ	Төсөл арга хэмжээ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Улс, орон нутаг, замын сангийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитыг дараах чиглэлийн хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад улс, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүн, Төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох сум албан байгууллага, зарим гүйцэтгэгч ААН-ийг хамрууллаа.

Арга зүй

Аудитын явцад холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналыг хянах, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтын явцыг тулган баталгаажуулах, хэрэгжилтийн үр дүнг биечлэн үзэх, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж мэдээ судалгаанд тулгуурлан дараах ажлыг гүйцэтгэв.

- Хуулийн шаардлагад нийцүүлсэн ТАХ-г төлөвлөж батлуулсан эсэх
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө ТАХ-ний гэрээний хэрэгжилт санхүүжилт үр нөлөөтэй, үр ашигтай байгаа эсэхийг шалгаж Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан .

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг аймгийн Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхжаргал аудитын стандартыг хангуулж, хянан зохион байгуулж, аудитор Я.Тунгалаг, ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор Т.Намжил, шинжээч Л.Бат-Очир нар хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.1 . Хэтийн төлөвлөгөөг үндэслэн 2016 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэл, нийгэм эдийн засгийн зорилтын хүрээнд 2016 онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтыг салбар яамдад хүргүүлсэн байна. Үүнд:

сая.төгрөг

Д/д	Яамны нэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2017 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн тоо	Мөнгөн дүн
1	Шадар сайд	3	3 200,0
2	Засгийн газрын хэрэг эрхлэх асуудлын хүрээнд	2	7 640,0
3	Хууль зүйн яам	4	3 139,0
4	Барилга хот байгуулалтын яам	12	17 385,0
5	Эрчим хүчний яам	6	7 946,6
6	Зам тээврийн яам	8	86 712,1
7	ЭМСортын яам	10	8 250,0
8	БСШУЯам	24	8 383,2
9	ХАХНХЯ	1	2 000,0
10	ХХААЯ	6	8 098,3
11	БОНХЯам	9	708,0
12	Сангийн яам	1	4 850,0
13	МТШХХГазрын хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил	1	11 700,0
	Нийт	87	170 012,2

Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 14 төсөл арга хэмжээний 1102.2 сая төгрөгийн эрх Төсвийн ерөнхийлөн захирагчид шилжин ирсэн байна.

Увс аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний эх үүсвэр дараах байдалтай батлагдаж санхүүжилт олгогдсон байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

Д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	2016 онд санхүүжих дүн	2016 онд олгосон санхүүжилт
1	Сургуулийн барилгын засвар /Увс, Завхан сум/	93.2	88.12
2	Увс аймгийн Цогцолбор 1-р сургуулийн сантехникийн засварын ажил	150.0	142.18
3	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай сум/	50.0	46.12
4	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Зүүнхангай сум/	50.0	47.2

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

5	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Тэс сум/	129.00	121.1
6	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Бөхмөрөн сум/	50.0	44.78
7	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Хяргас сум/	50.0	
8	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Ховд сум/	50.0	45.74
9	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Малчин сум/	50.0	46.65
10	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Завхан сум/	50.0	46.5
11	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Баруунтуруун сум/	50.00	47.47
12	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Цагаанхайрхан сум/	50.00	46.91
13	Тоног төхөөрөмж авах./Увс аймаг/	200.0	198.0
14	Сургуулийн барилгын засвар /Увс, Өлгий сум/	80,0	
	Дүн	1,102.2	920.8

А.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар үр ашиггүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 тоот тогтоолоор Увс аймагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг тодотгон баталсан байна. Орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сан, автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжих төсөл арга хэмжээний эх үүсвэрийг дараах байдлаар баталж санхүүжилт олгосон байна.

Д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	/сая төгрөгөөр/	
		2016 онд санхүүжих дүн	2016 онд олгосон санхүүжилт
	1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар :		
1	Зүүнхангай суманд орон сууц.	60.0	60.0
2	Нэгдсэн эмнэлэгт гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж.	5.0	5.0
3	Өндөрхангай суманд зайн оношлогооны багаж тоног, төхөөрөмж	14.0	14.0
4	Нэгдсэн эмнэлэгт эх барих цомог /нэг удаагийн/	18.9	18.9
5	Цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны засварын дутуу.	35.0	35.0
6	Ойрад түмний язгуур урлагийн олон улсын наадам	10.0	10.0
7	Цогцолбор 2-р сургуулийн дотуур байрны засварын санхүүжилтийн дутуу.	200.0	200.0
8	Орон сууц худалдан авах / орон нутгийн өмч 101/	70.0	70.0
9	Ахлах 4-р сургуулийн гадна авто зогсоолын өргөтгөл Улаангом 288м ²	19.0	18.7
10	1-48 айлын орон сууцны гадна авто зогсоолын өргөтгөл, Улаангом	16.0	15.7
11	Улаангом сумын 6-р багт Улиасны хэв чиглэлийн замд автобусны зогсоол хийх, 350 м шороон зам барих	16.0	15.7
12	Икел хөгжмийн талбайн тохижилт, Улаангом 3-р баг	15.0	14.8
13	30 айлын орон сууцны хэрэглээний халуун усны шугам холбох /Улаангом 3-р баг/	11.0	11.0
14	Хатан түрүү ОНӨААТҮГ-ын өр барагдуулах	50.0	49.8
15	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварт дэмжлэг /ходоодны дуран/	10.0	10.0

2. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар :			
1	Баруунтуруун сумын Шар ширэнгэд уулын ойжуулалт хийх	21.0	20.1
2	Увс аймгийн нутаг дэвсгэрт нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө хийх.	20.0	19.9
3	Увс аймгийн Улаангом сумын зам дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах	61.5	61.0
3. Автозамын сангийн хөрөнгө оруулалтаар :			
1	Наранбулаг сумын үерийн хамгаалалтын шуудуу татах	10.0	9.7
2	Увс аймгийн Зүүнговь сумын Гурамсны гүүр чиглэлийн замыг засаж сайжруулах.	50.0	38.7
3	Увс аймгийн Улаангом сумын Чандманий 1-р буудлаас 2-р буудал хүртэлх замыг засаж сэлбэх.	40.0	34.5
4	Улаангом сумын үерийн далан засварлах.	10.0	10.0
5	Увс аймгийн Улаангом сумын 4-р сургуулийн гадна авто зогсоол хийх	20.0	17.5
6	1-48 айлын гадна зогсоол хийх .	15.0	12.9
7	Гашууны гол чиглэлийн замыг засаж сайжруулах	32.5	26.5
8	8-р багт Хөндлөнгийн гарам барих	25.0	24.1
Нийт дүн		854.9	823.3

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх шилжиж ирсэн 200,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах эх үүсвэрийг 3 багц болгон худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

- 1-р багц аймгийн ЗДТГ-т Prado150 жийп машин авах,
- 2-р багц Улаангом сумын өрхийн эмнэлэгт суудлын машин авах,
- 3-р багц сумын ЭМТ-үүд, ИХШХЕГ-ын Баруун бүс дэхь газрын Увс аймаг дахь албанд туулах чадвар сайтай машин бэлтгэн нийлүүлэх

Төсвийн тухай хуулийн 4.1.24.-т ¹, 6.6.6.-т ² заасныг зөрчин тухайн орон нутгийн төсөвт хамааралгүй хуулийн этгээд болох 1-р багийн Өрхийн эрүүл мэндийн төвд олгосон автомашиныг буцааж аймгийн ЗДТГ-т шилжүүлэн авсан байна. Мөн ИХШХЕГ-ын харьяа Увс аймаг дахь албанд 29,5 сая төгрөгийн өртөгтэй УАЗ Hunter маркын автомашиныг бэлтгэн нийлүүлсэн алдаа зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага тогтоолоо.

Сангийн сайдын 2012 оны 264 тоот тушаалаар баталсан ТБОНӨХБАУХА ажиллагааг төлөвлөх тайлагнах журмын 2.1-д³ заасан **үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг** баримтлахгүйгээр орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2 орон сууц худалдан авахаар төлөвлөгөө баталжээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын шийдвэр, огноо	Тогтоолын дугаар	Хөрөнгийн эх үүсвэр	Хөрөнгийн зориулалт	Мөнгөн дүн /сая.төг/
2016 оны төсвийн тодотгол батлах тухай. /4-р хавсралт/ 2015.03.03	№ 9/01	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Орон сууц худалдан авах/орон нутгийн өмч/	70,0
2016 оны төсөв батлах тухай. /тодотголоор/ 2015.11.26	№10/07	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Зүүнхангай суманд орон сууц	60,0
ДҮН				130,0

1 4.1.24.-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

2 6.6.6.-т "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

³.2.1.-д Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн.....худалдан авах бараа үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулах.

Сангийн сайдын 2011 оны 132 тоот тушаалаар төрийн албан хаагч аймагт ажиллах томилолтын зам хоног, байрны зардлын тарифыг тогтоосон, төсөвт байгууллагуудын тухайн жилийн төсөвт томилолтын зардлыг төсөвлөсөн байдаг.

Гэтэл 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Зүүнхангай сумаас албан болон бусад ажлаар ирсэн хүмүүс байрлах зориулалтаар 60.0 сая төгрөгийн орон сууц худалдан авсан байна.

Түүнчлэн аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй 2 орон сууц байхад 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар нэмж орон сууц худалдан авсан байна. Тухайн орон сууцыг ямар зориулалтаар бэлтгэсэн, ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцыг ямар зориулалтаар ашигладаг талаар тайлбар тодруулга авахад нэг орон сууцанд Цэргийн штабын даргаар ажиллаж байсан албан хаагч амьдарч байгаа 5-р сард гэрээний хугацаа дуусна гэсэн тайлбар өглөө.

Цагдаагийн газар, Онцгой байдлын газар нь босоо тогтолцоотой тухайн байгууллагууд нь албан хаагчдыг орон байраар хангах чиг үүрэгтэй байдаг.

Дээрх ЗДТГ-ын 2 орон сууцанд Цагдаагийн орлогч дарга, Онцгой байдлын хэлтсийн дарга нар байрлаж байна.

Цаашид улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг эдийн засгийн үр ашигт тулгуурлан төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

А.3. Газрын зөвшөөрөл, техникийн нөхцлийг олгосон төсөл арга хэмжээг 2016 онд төлөвлөсөн байна.

Увс аймагт 2016 онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл, техникийн нөхцлийг олгосон байна.

А.4. Автозамын сангийн эх үүсвэрээр хийгдэх 8 төсөл арга хэмжээг зураг төсөвгүйгээр төлөвлөж, 1 ажлын зурагт өөрчлөлт орсон байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д⁴ заасны дагуу аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 10 сумын тохижилтын багц, Цогцолбор 1-р сургуулийн засварын ажлын хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг бүрэн хийсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчин орон нутгийн замын сангийн эх үүсвэрээр хийгдсэн 202.5 сая төгрөгийг зам гүүрийн арчлалтын зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө төсөвлөсөн байна.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБХ –ийн зам тээвэр мэдээлэл харилцаа холбооны асуудал хариуцсан мэргэжилтэнээс тодруулахад орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төсөвт өртөг бага учир гүйцэтгэгчтэй түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гэрээ байгуулдаг гэсэн тайлбар өглөө.

Гэтэл автозамын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гэрээг үзэхэд түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр байгуулсан гэрээ байхгүй байлаа.

Автозамын сангийн эх үүсвэрээр хийгдэх төсөл арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөвтэйгээр баталж байхыг зөвлөмж болголоо.

⁴29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн зураг төсвөө батлуулсан хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана.

Ховд аймгийн Алтай газрын хүч ХХК-иар гүйцэтгүүлсэн зурагт Завхан сумын сургуулийн барилгын засварын ажлын өртөг 389.4 сая төгрөг байхаар гарсан байна.

Харин 2016 оны Төсвийн тухай хуулиар Завхан сумын сургуулийн барилгын засварын төсөл арга хэмжээнд 93.2 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Иймээс аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн төсвийн дагуу ТЭЗҮ, зурагт төсөвт өөрчлөлт оруулжээ.

А.5. Төсвийн тухай хуулиар зарим төсөл арга хэмжээг хасаж баталсан байна.

Эрх шилжиж ирсэн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24 төсөл арга хэмжээнд 14329.9 сая төгрөгийг баталсан ба тодотголоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 төсөл арга хэмжээнд 6464.2 сая, Хөгжлийн банкны эх үүсвэрээр 3 төсөл арга хэмжээнд 6577.4 сая, нийт 15 төсөл арга хэмжээнд 13041.6 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 10/07 тоот тогтоолоор Увс аймагт 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, замын сангийн эх үүсвэрээр хийх 26 төсөл арга хэмжээнд 633.7 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 5-р сарын 20-ны өдрийн 11/05 тоот тогтоолоор 27 төсөл арга хэмжээнд 865,3 сая, 2016 оны 10-р сарын 21-ны өдрийн 2/01 тоот тогтоолоор 24 төсөл арга хэмжээний 854.9 сая төгрөгийн эх үүсвэрийг тодотгон баталжээ.

А.6. БСШУЯ-наас хувиарласан хөрөнгөөс 16.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирээгүй байна.

Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн 14 төсөл арга хэмжээ, аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын 25 төсөл арга хэмжээний нэр, байршил, эхлэх дуусах хугацаа, ангилал зөрүүтэй тусгагдаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсрол салбарт автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэн төсөл арга хэмжээнээс Увс аймгийн Боловсрол соёлын газар, аймгийн төв болон сумдын 20 сургууль, 4 цэцэрлэгт 456.5 сая төгрөгийн хөрөнгө хуваарилсан байна.

БСШУЯ-наас хуваарилагдсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоос Тариалан сумын Ахлах сургуульд 3 нэр төрлийн 5 ширхэг 7.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Ховд сумын Ахлах сургуульд **8.9 сая төгрөгийн Физикийн лабораторийн тоног төхөөрөмж ирээгүй** байсан тул судалгааг гарган баримтжуулж Үндэсний аудитын газарт хүргүүлжээ.

Мөн Улаангом сумын 9-р цэцэрлэгт хуваарилсан 9 нэр төрлийн 3.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шинээр баригдаж байгаа Хүүхдийн цэцэрлэгт олгох зориулалтаар ашиглаагүй, данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

А.7. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулан санхүүжүүлжээ.

Улсын төсвийн эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын холбогдох заалтыг үндэслэн 11 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагч хяналтаар баталгаажуулж холбогдох яаманд хүргүүлэн 611.5 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн төрийн сангаар дамжуулан гүйцэтгэгчид олгосон байна.

Захиалагчийн хяналтаар баталгаажуулсан орон нутгийн хөрөнгө оруулалтын 12 төсөл арга хэмжээний 239.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

Түүнчлэн төсвийн шууд захирагчид эрх шилжсүүлсэн 7 төсөл арга хэмжээний 106,9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгожээ.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 130.0 сая төгрөгийн 2 орон сууц худалдан авах үр ашиггүй төсөл арга хэмжээнд *төсөв* баталжээ .
2. ТЭЗҮ , зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг автозамын сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбатад:

1. Эдийн засгийн хувьд үр ашигтай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж байх.
2. ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөхгүй байх.

БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулжээ.

Б.1. Үнэлгээний хороог журмын дагуу байгуулж ХАА-ны аргыг зөв сонгосон ч 2 төсөл арга хэмжээг мэдээллээгүй байна.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны алба 2016 онд 2392.7 сая төгрөгийн өртөгтэй 33 багц бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа төлөвлөжээ.

Худалдан авах ажиллагааны алба 2016 онд 26 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр нь захирамжаар томилсон байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь хууль тогтоомжид заасны дагуу тендерийн сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцохдоо ашиг сонирхолын урьдчилсан мэдэгдлийг тухай бүр нь мэдүүлж байна.

Худалдан авах ажиллагааны алба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн 10 сумын тохижилт 1 багц, 2 сургуулийн их засвар, тоног төхөөрөмж худалдан авах 1 багц, орон нутгийн болон замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтын 23, нийт 26 төсөл арга хэмжээний худалдан авах ажлыг зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны алба улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн болон замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 12 удаа цаасаар, 29 удаа цахим сайтад байршуулан зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны урилгыг *e-procurement.mn*, *uvstender.mn* цахим хаяг, Увс телевиз, МВС, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз, Өглөөний сонин, Увсын өнгө сонингоор олон нийтэд мэдээллэсэн байна.

Харин орон нутгийн хөрөнгө оруулалтын байгууллагад эрх шилжсэн 2 төсөл арга хэмжээг ТБНӨХБАҮХА тухай хуулийн 21-д⁵ заасныг зөрчин тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээллээгүй байна. Иймд ТБНӨХБАҮХА тухай хуулийн 21 дэх заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болголоо. /Энэ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн ЗДТГ-т 70,0 сая төгрөгөөр орон сууц, Зүүнхангай сумын ЗДТГ-т 60,0 сая төгрөгөөр орон сууц худалдан авах 2 төсөл арга хэмжээ байна./

Б.2. Засгийн газрын тогтоол зөрчиж 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны алба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй, 1 төсөл арга хэмжээний 10 багц ажлыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг сонгон зохион байгуулжээ.

Орон нутаг, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22 төсөл арга хэмжээнээс 18 төсөл арга хэмжээг харьцуулалтын арга, 4 төсөл арга, хэмжээг шууд гэрээ байгуулах аргыг сонгон гүйцэтгэгчийг шалгаруулсан байна. Худалдан авах ажиллагааны байдлыг графикаар харуулбал:

⁵ ТБНӨХБАҮХА тухай хуулийн 21-д “ захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутамын сонин хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.”



Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх босго үнээс ⁶ дээш өртөгтэй барааг худалдан авахдаа нээлттэй тендер шалгаруулалтын аргыг сонгохоор заасан байхад Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжсэн 2 төсөл арга хэмжээнд харьцуулалтын арга сонгож уг тогтоолыг зөрчсөн байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн ЗДТГ 70,0 сая төгрөгөөр орон сууц худалдан авах
- Зүүнхангай сумын ЗДТГ 60,0 сая төгрөгөөр аймгийн төвд орон сууц худалдан авах

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолын хавсралтаар баталсан босго үнийг мөрдөж ажиллахыг зөвлөмж болголоо.

Худалдан авах ажиллагааны алба 2016 оны худалдан авах ажиллагааны үр дүнг Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтын дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхий захирагчийн сайтад мэдээллээ байршуулсан байна. Харин зарим сард Шилэн дансны тухай **хуулинд заагдсан хугацаанд** мэдээллийг байршуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулав.

Шилэн дансны мэдээллийн төрөл	Шилэн дансанд байршуулсан нийт мэдээллийн тоо	Үүнээс	
		Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хуулийн хугацаанаас хоцорч байршуулсан мэдээллийн тоо
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	1	1	
Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	11	6	5
Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	11	8	3
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	6	2	4
Худалдан авах ажиллагааны тайлан	1	1	
ДҮН	30	18	12

⁶“Харьцуулалын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 50 хүртэл сая төгрөгийн барааг худалдан авахдаа нээлттэй тендер шалгаруулах аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах”

Худалдан авах ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйл заасан хугацаанд тухай бүр мэдээллэж байхыг зөвлөж байна.

Б.3. Хуульд заасан хугацаанд ХАА-г зохион байгуулж, тайлагнасан байна.

Худалдан авах ажиллагааны алба нь Сангийн сайдын 2012 оны 264 тоот баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 2016 оны улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөгөө, тайланг аймгийн Засаг даргаар баталгаажуулан шилэн дансны сайт, uvstender.mn хаягт байршуулан олон нийтэд мэдээллэсэн байна.

Увс аймгийн хэмжээнд зохион байгуулсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 13, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 24 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулсан байна.

Б.4. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 42.6 сая төгрөгийн хэмнэлтийг зарцуулаагүй байна.

Увс аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн 872.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй 4 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас тендерт шалгарсан төсөвт өртөг 859.3 мянган төгрөг болж 12.9 сая төгрөгийн хэмнэлт гарчээ.

Өмнөх онд хийгдсэн санхүүжилтийн дутууд 235.0 сая төгрөг олгогдсон байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний 457.4 сая төгрөгт худалдан авах ажиллагаа зохион байгуулснаас тендерт шалгарсан төсөвт өртөг 427.6 сая төгрөг болж 29.7 сая төгрөгийг хэмнэжээ.

Хэмнэлтийн үлдэгдэл дүнд замын сангаас хийгдсэн төсөл арга хэмжээний төсөвлөгдсөн техник хяналтын зардлын 4.4 сая төгрөг орсон байна.

Тээвэр авто замын газар татан буугдаж холбогдох мэргэжилтэн нь аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст харьяалагдаж захиалагчийн хяналтыг хийж байна.

Б.5. Худалдан авах ажиллагааны эрх оройтон шилжиж ирснээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх нь харилцан адилгүй хугацаанд шилжиж ирсэн байна. Тухайлбал:

- Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний эрх 1-р сард
- Завхан сумын Сургуулийн дээврийн засварын ажлын эрх 3-р сард
- 10 сумын тохижилтийн ажлын эрх 4-р сард
- Цогцолбор 1-р сургуулийн сантехникийн засварын ажлын эрх 9-р сард
- Өлгий сумын Ахлах сургуулийн сургуулийн засварын ажлын эрх 12 сард

Худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирснээс хойш 1-8 сарын дараа үнэлгээний хороо байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнээс барилга байгууламжийн их засвар хийх 2 ажлын эрх БСШУЯ-наас оройтож ирснээр 1 ажил нь хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- БСШУЯ-ны сайдын 2016 оны 9-р сарын 1-ний А/18 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Увс аймгийн Цогцолбор 1-р сургуулийн сантехникийн засварын ажлын эрх шилжиж ирсэн байна. Ингэснээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч гэрээнд заасны дагуу ажлыг 12 сарын 1-нд хүлээлгэн өгчээ. Уг ажлыг сургалтын үеэр, хүйтний улиралд хийж гүйцэтгэсэн ба сургуулийн багш, ажилтан албан хаагч, сурагчдад хүйтэн орчинд ажиллах суралцахад багагүй чирэгдэл гарсан байна.
- Өлгий сумын сургуулийн завсарын ажлын худалдан авах ажиллагааны эрх 2016 оны 12-р сард ирсэн тул худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Цаашид Монгол улсын төсвийн тухай хуулиар баталсан улирлын чанартай хийгдэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг хугацаа алдахгүйгээр нь төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлж байхыг зөвлөмж болголоо.

Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 7 төсөл арга хэмжээ / 2016 оны 2 сард 5, 4 сард 1, 10 сард 1 төсөл/-ний эрхийг тухайн байгууллагад шилжүүлж худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах чиглэл өгчээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн Завхан сумын сургуулийн барилгын засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч гүйцэтгэгч ирээгүй, шалгарсан гүйцэтгэгч шаардлага хангаагүй, зураг нь үндэслэлгүй хийгдсэн зэрэг шалтгаанаар 5 удаа зарлагдаж 164 хоног үргэлжилжээ.

Б.6. ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчлөөгүй байна.

Худалдан авах ажиллагааны алба Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хууль, ИТХ-ын баталсан төсөл арга хэмжээний зориулалтанд өөрчлөлт оруулахгүй захилагчийн өгсөн ажлын даалгаварын дагуу тендерийн жишиг бичиг баримтыг боловсруулан техникийн тодорхойлолтод тусган худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улс, орон нутаг, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт 26 төсөл арга хэмжээнээс 24 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулж, 2 төсөл арга хэмжээг олон нийтэд мэдээллээгүй байна.
2. Худалдан авах ажиллагааны урилгыг цахим хаягаар мэдээллэж 4 төсөл арга хэмжээг нээлттэй, 1 төслийн 10 багц ажилд хязгаарлагдмал, 4 ажилд шууд гэрээгээр гүйцэтгүүлэх, 18 ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.
3. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөгөөс гүйцэтгэлээр 42.7 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

4. ЗГ-ын тогтоолоор баталсан журмыг зөрчин босго үнээс дээш өртөгтэй барааг нээлттэй тендер шалгаруулалтын аргыг сонгохгүйгээр харьцуулалтын аргаар бэлтгэсэн байна.
5. БСШУЯ-наас улирлын чанартай хийгдэх 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх оройтож шилжин ирсэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтын газарт

1. Монгол улсын төсвийн тухай хуулиар батлагдсан улирлын чанартай хийгдэх төсөл арга хэмжээний эрхийг хугацаа алдахгүйгээр шилжүүлж байх.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт

2. Тендерийн сонгон шалгаруулалтын урилгыг хууль тогтоомжийн дагуу нийтэд бүрэн мэдээллэж байх.
3. Засгийн газраас гаргасан журмын дагуу босго үнийг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

В.1. Гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгч нар төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 20 төсөл арга хэмжээг гүйцэтгэх 28 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлд хийгдэх ажлын даалгавар, тоо хэмжээг нь тодорхой тусгасан, гүйцэтгэх хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 10 сумын тохижилтын ажлаас Хяргас сумын төвийн тохижилтын ажлын тендерт шалгарсан **гүйцэтгэгчийн** эрүүл мэндийн шалтгаанаас ажил нь хийгдээгүй байна.

Гэрээний дуусах хугацаанд гүйцэтгэгч тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгээгүй нөхцөлд тооцох хариуцлагын талаар гэрээнд ямар нэгэн заалт ороогүй байна. Иймд цаашид захиалагч гэрээ байгуулахдаа ажлаа гүйцэтгээгүй нөхцөлд гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах, дахин худалдан авах ажиллагааг зохион байгуулж байхыг зөвлөж байна.

В.2. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ, аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалт, автозамын сан, байгаль хамгаалах сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээ, өмнөх оны дутуу санхүүжилт нийт 1445.9 сая төгрөгийг гүйцэтгэлд үндэслэн эх үүсвэрийг олгож зориулалтын дагуу зарцуулсан байна.

В.3. Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон байна.

2016 онд хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, улсын комиссын акт дүгнэлтийг үндэслэн санхүүжүүлэх эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнд 959.7 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтын 518.2 төгрөгийг олгож барилгын барьцаа дансанд нийт 61.1 сая төгрөг байршуулжээ.

Хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний хувьд ТЭЗҮ, зураг, төсөвт өртөгт нь өөрчлөлт ороогүй байна.

Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3-д⁷ заасныг зөрчин гүйцэтгэл нь бүрэн хийгдээгүй 2 ажлыг улсын комисс ажлын даалгавартайгаар хүлээн авч санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

1. Тэс сумын "Таван улиас" бага сургуулийн их засварын ажлыг Хүдэнгийн Уурхай ХХК-ни 127.5 сая төгрөгийн өртөгөөр 2016 оны 10 сарын 26-наас 12 сарын 06-ны хооронд хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гэрээний ажлыг хүйтний улиралд гүйцэтгэснээс зарим ажил дутуу, чанар муутай хийгдсэн, шалны будаг ховхорсон, хаалганы цоож, бариул эвдэрсэн, босоо рамууд хагарч унасан, уурын зуухны насос ачааллыг даахгүй байгаа, гал зуухны паарны халаалт муу зэрэг зөрчлүүд байна.

⁷Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухай барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна.

Их засварын ажлыг ашиглалтанд оруулах улсын комисс 2016 оны 12 сарын 13-ны өдөр даалгавартайгаар хүлээн авсан байна. Үүнд: Нэг өрөөнд 9.6 м² дулаалгатай парктен шал хийх, дээврийн дутуу будгийг гүйцээж будах, яндангийн татлага татуургыг бэхлэх, аянга зайлуулагч, газардуулагыг гагнах, цахилгааны самбарын товъёог хийж тавих, халаалтын узелийн өрөөнд зургийн дагуу хэмжих хэрэгсэл насосыг байрлуулах зэрэг дутуу ажлыг 2017 оны 06-р сарын 01-ний хийж гүйцэтгэх даалгавар өгсөн байна.

2. Нью Эрхэм ХХК-ний гүйцэтгэсэн 49,9 сая төгрөгийн өртөгтэй Малчин сумын төвийн тохижилтын ажлаас гэрэлтүүлгийн шонгуудад аянга зайлуулагч, газардуулга хийх, хог түрж отволдох, хогийн цэгт зон татах, сагсан бөмбөгийн талбайг будаж тэмдэг тэмдэглэгээ хийх, үлдэх 6 тоглоом тавьж угсрах ажлыг хийгээгүй байна.
3. Хүдэнгийн Уурхай ХХК-ний гүйцэтгэсэн 49,4 сая төгрөгийн өртөгтэй Цагаанхайрхан сумын 100 ортой Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын ажлыг 2016 оны 10-р сарын 24-нөөс 12-р сарын 20-нд хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан ч **гадна талын засварыг** 2017 оны 6-р сарын 1-ний дотор хийж гүйцэтгэхээр хойшлуулсан байна.



/Цагаанхайрхан сумын 100 ортой Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар/

Мөн дээрх журмын 3.20.3-д ⁸ заалтыг зөрчин Хүдэнгийн Уурхай ХХК-д Цагаанхайрхан сумын тохижилт, Нью Эрхэм ХХК-д Малчин сумын тохижилтын дутуу ажлын санхүүжилтийг банкны баталгаа үндэслэхгүйгээр бүрэн олгосон байна.

В.4. Гурван төсөл арга хэмжээний гэрээний хугацаа хэтэрсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа 14-150 хоногоор хэтэрсэн ч нэмэлт гэрээ байгуулж хугацаа сунгаагүй байна.

Улаангом сумын үерийн далан засварлах ажлын хувьд гэрээг дүгнэж гүйцэтгэл гаргасан ч санхүүжилтийг гэрээнд заасан хугацаандаа олгоогүйгээс гэрээний хугацаа хэтэрсэн байна. Үлдэх 2 төсөл арга хэмжээний хувьд гэрээний хугацааг 14-20 хоногоор хэтрүүлсэн ч гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хариуцлага тооцож ажиллаагүй байна.

⁸ Гэрээ байгуулсан боловч улирлын чанартай хийгдэх барилга угсралтын ажил гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд банкны баталгааг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгож болно.

Гэрээний хугацаа хэтэрсэн төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээ	Гүйцэтгэгч	Ажлыг эхлэх, хугацаа	гүйцэтгэж дуусах	Хугацаа хэтэрсэн хоног	Хугацаа хэтрүүлсэн шалтгаан
Увс аймгийн нутаг дэвсгэрт нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө хийх	Эко үйлчилгээний ТББ	2016.06.20-2016.10.01		14	Гүйцэтгэгчээс шалтгаалан хугацаа хэтэрсэн
Наранбулаг сумын үерийн хамгаалалтын шуудуу татах	АЗЗА ХХК	2016.06.06.-2016.07.10		20	Гүйцэтгэгчээс шалтгаалан хугацаа хэтэрсэн
Улаангом сумын үерийн далан засварлах. /замын сангаас/	Таваг чулуу ХХК	2016.5.16-2016.05.23		150	Санхүүжилтыг оройтож олгосон 2016.10.04

Цаашид гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу ажлыг хугацаандаа хийгээгүй гүйцэтгэгчид алданги тооцож ажиллахыг зөвлөмж болголоо.

В.5.Замын сангаар эх үүсвэрээр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд явцын хяналт хийгдээгүй байна.

Увс аймагт эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 13 төсөл арга хэмжээнд аймгийн ГХБХБГазрын барилга хариуцсан мэргэжилтэн 18 удаагийн хяналт тавьж илэрсэн алдаа зөрчилд тухай бүр албан шаардлага өгч ажиллажээ.


Харин 2016 оны орон нутгийн замын сангийн эх үүсвэрээр хийгдсэн ажилд явцын хяналт хийгдээгүй байна. Уг хөрөнгө оруулалтын ажилд хяналтыг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн зам тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн хийх ёстой байжээ. Гэтэл тухайн мэргэжилтэн 5-р сард өндөр настны тэтгэвэр гарч төрийн албаны зөвлөл ажлын байрны сонгон шалгаруулалт зарласан ч оролцогч ирээгүй шалтгаанаар 9 сард томилогоо хийгдсэн байна. Иймд автозамын сангийн эх үүсвэрээр 5-9 сард хийгдсэн төсөл арга хэмжээнд явцын хяналт хийгдээгүй байна

В.6. Улсын комиссын акт гараагүй байхад 1 ажлын санхүүжилтийг бүрэн олгожээ.

Улаангом сумын замын дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах 61.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг худалдан авах ажиллагааг 3 удаа зарлаж шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул үнэлгээний хорооноос ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4.3-д заалтыг үндэслэн Засаг даргад зөвлөмж хүргүүлсний дагуу Баянмандал ХХК –тай гэрээ байгуулсан байна. Ажлын гүйцэтгэх гэрээний 1.5-д “Гүйцэтгэгч 2016 оны 6-р сарын 10-наас 2016 оны 10-р сарын 25 хүртэл нөхөн тариалалт хийж ашиглалтанд оруулах ба 3 жилийн хугацаанд хамгаалалт, усалгаа арчилгааг бүрэн хариуцаж хүлээлгэн өгөх” гэж тусгажээ.

Мөн гэрээний 2.5-д “Гүйцэтгэгчийн ногоон байгууламжийн ажил барилга угсралтын ажлыг улсын комисс хүлээлгэн өгсөн акт болон гүйцэтгэлийг захиалагч хүлээн авсан дараа төлөх дүн 30 хувь болох 18,3 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг улсын комисс хүлээн аваагүй, гүйцэтгэл нь бүрэн гараагүй байхад олгосон байна.

Санхүүжилтийн бүрэн олгосон талаар БОАЖГаараас албан тоотоор ирүүлсэн тайлбарт “Улаангом суманд хийгдсэн ойжуулалтыг хүлээн авах комисс дүгнэхдээ тендер хойшлогдсон хавар мод тариалах хугацаа оройтсноос намар тарьсан, усны хаалттай холбоотой 4 ажил хийгдээгүй. Иймд дутуу ажлыг хийлгэж, модны ургалтын үр дүнг харж 2017 оны 6-р сард улсын комисс хүлээн авахаар шийдвэрлэсэн хурлын тэмдэглэлийг үндэслэн санхүүжилтийг бүрэн олгожээ. БОАЖГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар тухайн хөрөнгө оруулалтын ажлыг зардалд тайлагнасныг дуусаагүй барилга, дутуу гүйцэтгэлд олгогдсон санхүүжилтийг авлагаар тусгуулан залруулга хийлгэсэн байна.



/ Улаангом сумын замын дагуу хамгаалалтын ойн зурвас/

В.7. Зарим төсөл арга хэмжээний чанар хангалтгүй байна.

Улсын комисс хүлээн авсан улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг аудитын баг газар дээр нь үзэхэд зарим төсөл арга хэмжээний хийгдэх ажил дутуу, чанаргүй хийгдсэн зөрчил илэрснийг арилгуулахаар албан шаардлага өглөө. Үүнд:

- Содмандах ХХК-ний 48.5 сая төгрөгийн өртөгөөр хийсэн Өндөрхангай сумын төвийн тохижилтын ажлын гүйцэтгэлийг үзэхэд зарим хашлага бетоныг зурагт заасан хэмжээнд суулгаж цутгаагүйгээс унасан, зарим хашаа салсан байна.



/Өндөрхангай сумын ногоон байгууламжийн хашаа/

- Хөрөнгийн бэл ХХК-ний гүйцэтгэсэн 49.7 сая төгрөгийн өртөгтэй Зүүнхангай сумын Соёлын төвийн барилгын дээврийн засварын ажлын гүйцэтгэлийг хянаж үзэхэд гөлмөн төмрөн малгайвч нь унасан байна.
- Тэнгэрлэг хийц ХХК-ний Ховд сумын төвд 48.1 сая төгрөгийн өртөгөөр гүйцэтгэсэн цемент бетоны хольцтой зам, Бөхмөрөн сумын төвд 47,1 сая төгрөгийн өртөгтэй гүйцэтгэсэн цементен цутгамал замын ажлыг улсын комисст 2016 оны 11 сард хүлээлгэн өгсөн байна. Тухайн ажлыг

хэрэгжилтийг 2017 оны 3-р сард буюу ашиглалтанд орсноос хойш 4 сарын дараа үзэхэд замын зарим хэсэгт хөндлөн цууралтууд үүссэн байна.



/Бөхмөрөн сумын төвд хийгдсэн зам/

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт дээрх зөрчлүүдийг арилгуулах талаар албан тоот, албан шаардлагыг хүргүүлэв.

Сангийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 5.1-д⁹ заасныг зөрчин БСШУЯ, ЭМЯ-наас ирсэн 95,6 сая төгрөгийн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага тогтоолоо. Үүнд:

БСШУЯ-наас :

- Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд , ахлах болон дунд сургуулиудад 24 ш /самбар, самбарын хөл, проектор/

- Боловсролын байгууллагуудад хуваариласан дээрх хөрөнгүүдийг данс бүртгэлтэй тулган баталгаажуулж тооллого хийхэд 11 сургууль нийт 84,6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэл тусгаагүй байна.

- Түүнчлэн Тэс сумын Ахлах сургуульд ус буцалгагч 201.0 мянга, цахилгаан махны машин 680.8 мянга ирснээр данс бүртгэлд тусгасан боловч тухайн хөрөнгө нь биетээр байгаагүй тул зөрчил арилгуулах албан шаардлага тогтоолоо.

ЭМЯ-наас:

- Өмнөговь сумын Эрүүл мэндийн төвд хуваариласан 5 төрлийн 11,0 сая төгрөгийн эмчилгээний зориулалтай тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Эрүүл мэнд спортын яамнаас 2016 онд Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн хүрээнд Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн цусны салбарт 44 нэр төрлийн 361.5 сая төгрөгийн цусны тоног төхөөрөмжийг хуваариласан байна. Дээрх хөрөнгөнөөс 8,3 сая төгрөгийн үнэ бүхий Иммуногематологийн термостат К37-24 маркын төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай центрифуг байхгүйгээс ашиглахгүй байгаа гэсэн тайлбарыг эд хариуцагч нь өглөө. Иймд тухайн асуудлыг яаманд хандаж шийдвэрлүүлэхийг зөвлөлөө.

Аудитаар нийт зөрчил арилгуулах 157,2 сая төгрөгийн 26 албан шаардлага өгсөн болно.

⁹“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр нь тухайн төсөвт байгууллагын тайлан балансад бүртгэнэ”

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.
2. Хоёр гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Батсайханд

1. Сангийн сайдын баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ыг мөрдөж ажиллах.
2. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж хугацаа хэтэрсэн нөхцөлд гүйцэтгэгчид хариуцлага тооцож байх.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

213400, Улаангом, Увс аймаг
Регистр: 9062858 ш/х: 267
Утас/Факс: 70452113


2019.04.20 № 114
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны захиалга, Аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу " Улс , орон нутгийн төсвийн хөрөнгөөр Увс аймагт 2016 онд санхүүжигдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Уг гүйцэтгэлийн аудит хийхдээ төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох сум, байгууллага, зарим гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулсан байна.

Танай хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан газрын албан тушаалтнуудаар хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  Э.НАСАНБАТ





**УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

213400, Улаангом, Увс аймаг
Утас/Факс: 7045-2012

2017.04.20 № 5/483
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн улс, орон нутаг, замын сангийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. ИХШХЕГ-ын харьяа Увс аймаг дахь албанд нийлүүлсэн 29.5 сая төгрөгийн өртөгтэй УАЗ Hunter маркын автомашиныг орон нутгийн өмчид шилжүүлж авах.
2. Цагдаагийн газар, Онцгой байдлын газарт ашиглагдаж буй орон сууцнуудыг тухайн шатны зориулалтын дагуу ашиглах талаар албан шаардлага болгон өөрчлөлт оруулж өгнө үү.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЭРДЭНЭСҮРЭН



12 642

My; doc zasag-A5



**УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

85160, Улаангом, Увс аймаг

Утас/факс: 70452232

2017.04.20 № 76

танай _____ -ны № _____ -тоот

Г АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ Г

Увс аймагт, улс, орон нутагт замын сангийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Худалдан авах ажиллагаатай холбоотой дүгнэлттэй санал нэг байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.


ДАРГА М.УЛААНХҮҮ

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу.

- Аймгийн ИТХ-ын ирүүлсэн саналд:

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн албан тоот ирсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

- Засаг даргын ирүүлсэн саналд:

1. Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин ИТШХЕГ-ын харьяа Увс аймаг дахь албанд нийлүүлсэн 29.5 сая төгрөгийн УАЗ Hunter маркын машиныг Орон нутгийн өмчид шилжүүлэх албан шаардлага болгох саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулан зөрчил арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
2. Цагдаагийн газар, Онцгой байдлын газарт ашиглагдаж буй орон сууцнуудыг тухай шатны зориулалтын дагуу ашиглуулах талаар албан шаардлага болгон өөрчлөх саналыг хэлэлцээд Тухайн шатны төсвийн захирагчийн эрх хэмжээний асуудал тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ.

- Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны ирүүлсэн саналд:

Тайлангийн төсөлд тусгагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой дүгнэлттэй санал нэг байна гэсэн тул хариу тайлбар өгөх шаардлагагүй.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

**Я.ТУНГАЛАГ
Т.НАМЖИЛ**